

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ  
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч эрчим хүчиний 5 мегаваттаас дээш хүчин чадалтай, дулааны эрчим хүчиний 1.5 мегаваттаас дээш хүчин чадалтай эх үүсвэр барих, суурилагдсан хүчин чадлыг өргөтгөх, тухайн шинэ эх үүсвэрийг цахилгаан дулаан хангамжийн системд холбох шугам болон дагалдах дэд бүтцийн төслийн үндсэн хөрөнгөд бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортын тоног төхөөрөмжийг 2029 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл гаалийн албан татвараас бүрэн чөлөөлөх, мөн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жилээр сунгах, эсхүл Засгийн газрын шийдвэрээр 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх харилцааг зохицуулахаар хуулийн төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хамаарах эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир эрчим хүчиний хэрэглээний хүчин чадал, өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлага болон цаашид хэрэгжүүлэх томоохон төслийн талаар, мөн эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэнээр үнэ тариф буурах боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, тогтвортжуулалтын гэрчилгээ олгосон болон цаашид шинээр гэрээ байгуулахдаа энэ удаагийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хувь хэмжээг тогтвортжуулахгүйгээр 2030 он хүртэл хэрэгжихээр зохицуулах нь зүйтэй гэсэн санал хэлэв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх буюу 80.0 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал,

дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

